



ХДХВ ба хүүхэдтэй болох

2023 оны 4 сар

ХДХВ-ийн халдвартай хүмүүс ХДХВ-г хамтрагч эсвэл хүүхдэдээ дамжуулалгүйгээр эрүүл хүүхэдтэй болох боломжтой. Эхээс хүүхдэд ХДХВ халдах тохиолдол Австралид ховор байдаг.

ХДХВ-ийн эмээ уух болон эрүүл мэндийн ажилтнуудын туслалцаатайгаар:

- ХДХВ-тэй эмэгтэй уг вирусыг хамтрагчдаа халдаахгүйгээр жирэмслэх боломжтой
- ХДХВ-тэй эмэгтэйчүүд хүүхэддээ уг вирусын халдвар дамжих эрсдэлийг бараг тэг хүртэл бууруулах боломжтой (<1%)
- ХДХВ-ийн халдвартай эрэгтэйчүүд ХДХВ-ийн халдварыг хамтрагч эсвэл хүүхэддээ халдаалгүйгээр хүүхэдтэй болох боломжтой

Хүүхэдтэй болоход бэлтгэх нь

Хэрэв та, таны хамтрагч эсвэл хоёулаа ХДХВ-тэй бөгөөд хүүхэдтэй болохоор төлөвлөж байгаа бол эмчдээ энэ талаар хэлэх хэрэгтэй. Ингэснээр эмч тань хамгийн аюулгүй жирэмслэх арга болон ХДХВ-ын халдваргүй хүүхэд төрүүлэх арга замыг зөвлөх болно.

Мөн жирэмсэн үед хэрэглэхэд аюулгүй ХДХВ-ын эсрэг эмийг зөвлөж, зохих дэмжлэгийг үзүүлнэ. Заримдаа төлөвлөөгүй үед жирэмсэн болох нь бий. Энэ тохиолдолд, эмчдээ аль болох хурдан үзүүлсэнээр тэд таныг шаардлагатай дэмжлэг, мэдээллээр хангах боломжтой.

Үргүйдэл

ХДХВ нь таны жирэмсэн болох чадварт нөлөөлж болзошгүй. Жирэмсэн болохоор оролдож эхэлснээс хойш нэг жилийн дотор жирэмсэн болоогүй тохиолдолд эмчдээ үзүүлэх хэрэгтэй. Эмч нар танд тохирох зөвлөгөө өгч, эсвэл нөхөн үржихүйн эмнэлэг рүү илгээнэ.

Илрүүлэх боломжгүй вирусын түвшин гэдэг нь таны цусан дахь ХДХВ-ын хэмжээ бусдад халдварлах боломжгүй бага хэмжээтэй байхыг хэлнэ. Энэ нь та ХДХВ-гүй болсон, эдгэрсэн гэсэн үг биш. Харин энэ нь цусан дахь вирусны хэмжээ бага бөгөөд бэлгийн харьцаагаар бусдад халдварлах боломжгүй гэсэн үг юм. Эмчийн бичиж өгсөн эмийг жорын дагуу уудаг ихэнх хүмүүсийн вирусны түвшин нь илрүүлэх боломжгүй бага түвшинд байх боломжтой юм.

ХДХВ-гүй хамтрагчтайгаа хүүхэдтэй болох

Хосуудын аль нэг нь ХДХВ-тэй тохиолдолд вирусаа эрүүл хамтрагчдаа халдаахгүйгээр жирэмсэн болох боломжтой. ХДХВ-тэй хамтрагч нь эмээ тогтмол ууж, вирусын хэмжээ нь илрүүлэх боломжгүй түвшинд байвал ХДХВ-ын халдвар дамжих эрсдэл байхгүй.

Вирусын ачаалал илрүүлэх боломжгүй түвшинд байгааг хянаж байхад тогтмол шинжилгээ өгч байх нь чухал. Жирэмслэхээр оролдож эхлэхээс өмнө хосууд бэлгийн замаар халдах өвчний шинжилгээ өгч, эмчлүүлэх хэрэгтэй.

ХДХВ-ийн халдваргүй хамтрагч нь ХДХВ-ийн халдвар авахаас урьдчилан сэргийлэхийн тулд жирэмсэн болохоор оролдож эхлэхээс өмнө болон оролдож байх хугацаандаа ХДХВ-ийн эм ууж болно. Энэ эмчилгээг PrEP (Pre-Exposure Prophylaxis буюу Өртөхөөс өмнөх Урьдчилан Сэргийлэлт) гэж нэрлэдэг бөгөөд ХДХВ-ийн халдвартай хамтрагчын цусан дахь вирус илрэхүйц түвшинд байгаа тохиолдолд нэмэлт сонголт болдог. Хэрэв та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл энэ талаар эмчтэйгээ ярилцаарай.

Жирэмсэн болохын тулд бэлгийн хавьталд ороход тохиромжтой өдрүүдийн талаар эмчтэйгээ ярилцаарай. Энэ нь жирэмслэх магадлалыг нэмэгдүүлэх болно (эмэгтэйчүүдийн сарын тэмдэг ирэхээс 2 долоо хоногийн өмнө). Энэ нь мөн таны хамтрагчид ХДХВ-ын халдвар дамжих магадлалыг бууруулна.

Хосууд хоёулаа ХДХВ-тэй тохиолдолд хүүхэдтэй болох

Хосууд хоёулаа ХДХВ-ын халдвартай байсан ч ХДХВ-гүй хүүхэдтэй болох боломжтой.

Хэрэв хосууд хоёулаа ХДХВ-ын эм ууж байгаа бөгөөд вирус нь цусанд илрэх боломжгүй түвшинд байвал хүүхдэд ХДХВ халдварлах эрсдэл бараг байхгүй.

ХДХВ-ын халдвар хүүхдэд дамжих эрсдэл

ХДХВ-тэй эмэгтэй жирэмсэн үедээ дараах зүйлсийг хэрэгжүүлвэл хүүхдэдээ ХДХВ-н халдвар дамжуулах эрсдлээ 1%-с бага болгож бууруулах боломжтой:

- ХДХВ-ийн эмээ уух. Эхийн вирусын ачаалал болон бусад нөхцөл байдлаас хамааран эмч хүүхдээ хэрхэн төрүүлэхийг зөвлөнө (кесараар эсвэл өөрөөрөө)
- Хүүхдээ хөхөөр хооллохгүй байх
- Төрсний дараа хүүхдэд ХДХВ-ын эсрэг эмчилгээ хийх (ихэвчлэн 4-6 долоо хоногийн турш)

Хэрэв ХДХВ-тэй эрэгтэй нь илрүүлэх боломжгүй вирусын түвшинтэй бөгөөд хамтрагч нь жирэмсэн үед ч ХДХВ-ын эмээ уусаар байгаа бол хамтрагчдаа эсвэл хүүхдэдээ ХДХВ дамжуулах эрсдэлгүй.

Хүүхэддээ нэмэлт сүү өгөх үү эсвэл хөхөөр хооллох уу?

Австралид ХДХВ-тэй ээжүүд хүүхдээ хооллох хамгийн аюулгүй арга бол нэмэлт сүүгээр хооллох гэж үздэг. Хөхний сүүгээр хооллох үед ХДХВ-ийн халдвар дамжих магадлал маш бага ч тэг БИШ. Өөрт болон хүүхдэдээ тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахын тулд эмчтэйгээ зөвлөлдөх нь чухал юм.

Шийдвэр гаргах

ХДХВ-тэй хүмүүс болон хамтрагчид нь хэзээ, хэрхэн хүүхэдтэй болохоо сонгох эрхтэй бөгөөд тэдний шийдвэрт хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Тэд шаардлагатай бүх мэдээллээр хангагдах эрхтэй бөгөөд эрүүл мэндийн ажилтны дэмжлэг туслалцаатайгаар өөрсдийн шийдвэрээ гаргах боломжтой.

Ашигтай холбоо барих хаягууд:

Pozhet (Heterosexual HIV Service)

ХДХВ-ийн халдвартай эсвэл түүнд өртөх эрсдэлтэй гетеросексуал хүмүүст зориулсан дэмжлэг, мэдээлэл, нэмэлт эмчилгээ үйлчилгээнд илгээх болон арга хэмжээ

Зохиодог

Phone: 1800 812 404

Website: www.pozhet.org.au

Email: pozhet@pozhet.org.au

Multicultural HIV and Hepatitis Service

Соёлын хувьд ялгаатай хувь хүмүүс болон нийгэмд зориулсан мэдээлэл, дэмжлэг туслалцаа үзүүлдэг

Phone: 1800 108 098

Website: www.mhahs.org.au

Email: info@mhahs.org.au

Positive Life NSW

ХДХВ-ийн халдвартай хүмүүст зориулсан олон нийтийн байгууллага

Phone: 1800 245 677

Website: www.positivelife.org.au

Email: contact@positivelife.org.au

Sexual Health Info Link

Доорх цахим хуудсаар орж өөрт ойр байрлах бэлгийн эрүүл мэндийн үйлчилгээний талаар мэдээлэл авна

Phone: 1800 451 624

Website: www.shil.nsw.gov.au

Email: seslhd-shilmail@health.nsw.gov.au

Local Sexual Health Clinic

Доорх цахим хуудсаар орж өөрт ойр байрлах бэлгийн эрүүл мэндийн үйлчилгээний талаар мэдээлэл авна уу

Website: www.health.nsw.gov.au/sexualhealth/Pages/sexual-health-clinics.aspx

The Albion Centre

ХДХВ-ийн халдвартай хүмүүсийг шинжилгээнд хамруулах, боловсрол олгох, зөвлөгөө өгнө.

Phone: (02) 9332 9600

Website: www.thealbioncentre.org.au

Email: education@thealbioncentre.org.au

The Paediatric HIV Service at Sydney Children's Hospital

ХДХВ-ийн халдвартай хүүхэд, гэр бүлд зориулсан эрүүл мэндийн менежмент, сэтгэл зүй-нийгмийн дэмжлэг, судалгаа, зөвлөгөө, боловсрол олгоно

Phone: (02) 9382 1508

Website: www.schn.health.nsw.gov.au/find-a-service/health-medical-services/immune-deficiency-and-hiv/sch

TIS National Translating and Interpreting Service

150 гаруй хэл дээр орчуулгын үйлчилгээг газар дээр нь болон утсаар үзүүлэх боломжтой

Phone: 13 14 50

Website: www.tisnational.gov.au

Email: tis.prebook@homeaffairs.gov.au